


2017 ОНД ИРГЭД, БАЙГУУЛЛАГААС ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН САНАЛ, ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ

Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2017 онд иргэд, байгууллагаас 11497 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2191 нэгжээр буюу 23.5 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 73 буюу 0.6 хувь нь санал, 11289 буюу 98.2 хувь нь өргөдөл, 135 буюу 1.2 хувь нь гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл,
гомдол



Санал, өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл: 1204 буюу 10.5 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 402 буюу 3.5 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1818 буюу 15.8 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 3152 буюу 27.4 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 654 буюу 5.7 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 4267 буюу 37.1 хувь нь бусад өргөдөл гомдол байна.



Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 11389 буюу 99.1 хувийг шийдвэрлэж, 108 буюу 0.9 хувь нь ажиллагаанд байна.



Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар

2017 онд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 794 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47 нэгжээр буюу 6.3 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 4 буюу 0.5 хувь нь санал, 32 буюу 4.0 хувь нь гомдол, 758 буюу 95.5 хувь нь өргөдөл байна.





Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 65 буюу 8.2 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 126 буюу 15.9 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 127 буюу 15.9 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 15 буюу 1.9 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 108 буюу 13.6 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 353 буюу 44.5 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Гурав. Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвд ирсэн өргөдөл, гомдол, шүүмжлэл, санал хүсэлтийн талаар

2017 онд иргэдээс Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 416 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 198 буюу 47.6 хувь нь санал хүсэлт, 165 буюу 39.7 хувь нь гомдол, 39 буюу 9.4 хувь нь талархал, 5 буюу 1.2 хувь нь шүүмжлэл, 9 буюу 2.1 хувь нь өргөдөл байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 327 буюу 78.6 хувийг шийдвэрлэж, 89 буюу 21.4 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 194 буюу 59.3 хувийг 5 хоногийн дотор, 133 буюу 40.7 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэжээ.

Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

2017 онд иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 1575 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 130 нэгжээр буюу 7.6 хувиар буурч, 1786 алба хаагч холбогдсоны 1482 буюу 83.0 хувь нь офицер, 297 буюу 16.6 хувь нь ахлагч, 7 буюу 0.4 хувь нь энгийн ажилтан байна. Нийт өргөдөл гомдлын 1485 буюу 94.3 хувийг шийдвэрлэж, 90 буюу 5.7 хувь нь ажиллагаанд шалгагдаж байна.

Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 97 буюу 6.2 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 130 буюу 8.3 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 10 буюу 0.6 хувь нь хэргийн хугацаа хэтэрсэн, 33 буюу 2.1 хувь нь бусдыг чирэгдүүлж танил тал харсан, 11 буюу 0.7 хувь нь хээль хахууль, шан харамж авсан, 361 буюу 22.9 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 92 буюу 5.8 хувь нь бусдыг зодож эрх чөлөөнд нь халдсан, 366 буюу 23.2 хувь нь ажлын хариуцлага алдсан, 36 буюу 2.3 хувь нь архи дан согтуурсан, 4 буюу 0.3 хувь нь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 416 буюу 26.4 хувь нь Эрүүгийн байцаан шийтгэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль дүрэм зөрчсөн, 1 буюу 0.1 хувь нь хувцасны болон бусад хангамж дутуу олгосон, 18 буюу 1.1 хувь нь бусад зөрчлүүд эзэлж байна.

Зөрчлийн төрөл



Сахилгын арга хэмжээ авагдсан байдлыг авч үзвэл: Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдолд шалгалтын ажиллагаа явуулж, 32 алба хаагчид эрүүгийн хэрэг үүсгэхээр шилжүүлж, 35 алба хаагчид албанаас халах, 13 алба хаагчид цол бууруулах, 242 алба хаагчийн цалинг бууруулах, 127 алба хаагчид сануулах сахилгын шийтгэл оногдуулж, 1085 алба хаагчид холбогдох өргөдөл, гомдолд алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нотлогдоогүй, 36 өргөдөл, гомдол нь алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдсон боловч хариуцлага тооцох хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр тус тус шийдвэрлэгдсэн байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС